ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 27 өдөр Дугаар А/09 Мандалговь

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны "Дүрэм батлах тухай" 33 дугаар тогтоолын хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.6 дэх хэсэг, Газрын дотоод журмын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 06 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай томилсугай. Үүнд:

| | |
|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц, дотоод хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Гишүүд: | Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| | Дэл уул, Цагаан суварга орчмын байгаль хамгаалагч |
| | Нягтлан бодогч |
| Нарийн бичгийн дарга: | Байгаль орчны хяналтын улсын байцаагч |

2."Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Н.ГАНТУЛГА

Tuhsaal A.docx

482401042